

**Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн  
боловсронгүй бус байдал, үр дагавар**

**The Imperfections of the Preliminary  
Hearing and its Consequences**

Энх-Ялалтын Энхзул

*Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.).*

*Улаанбаатар хот, Монгол Улс*

*zulaa.yalalt@gmail.com*

© E.Enkhzul, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International  
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

### [Товч утга]

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалт нь Монгол улсад урд өмнө нь шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа нэршилтэйгээр байсан боловч одооных шиг тухайчлан нэг үе шат болгон зохицуулаагүй юм. Тухайн хэргийг шийдвэрлэхэд яллагдагч болон хохирогч нар ижил хүний хувьд /human dignity/ тэнцүү хэмжээнд эрх, үүрэг эдэлж мөрдөн шалгах ажиллагаанд оролцох бөгөөд уг хүний эрхийг хангах, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа зэрэг хуульд заасан асуудлыг шийдвэрлэхээр хууль тогтоогч хуульчилсан болно. Гэвч тухайн зохицуулалт хууль тогтоогчдын хуульд тус зохицуулалтыг тусгах зорилго биелсэн боловч түүний үр дүн хангалтгүй хэрэгжиж буйтай холбогдуулан уг судалгааны ажлыг хийсэн болно. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг бүрэн хэрэгжихгүй шалтгаан нь хэргийн оролцогчдын идэвх, хууль дахь заавал хэлэлцүүлэг хийлгэхээр зохицуулаагүй байх заалт, гэм буруугийн шатанд ч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэгдэх үндэслэлээр прокурорт даалгавар өгч шүүх хуралдааныг хойшлуулах боломж олгосон зэрэг нөхцөл байдал нь прокурорт даалгах зохицуулалтын дор хэргийг мөрдөн байцаалтад буцаах, шүүгч өөрийн анхны дотоод итгэлээр гэм бурууг шүүж, яллах шүүхийн хэв шинжийг агуулах бөгөөд цаад талдаа мэтгэлцэх зарчим шүүхийн шатанд хэрэгжихгүй байх зэрэг үр дагаваруудыг практикт бий болгох болсон юм. Манай улстай ижил байдлаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулсан улс болоод мэтгэлцэх зарчим бүрэн хөгжсөн ялгаатай эрх зүйн тогтолцоотой улсыг харьцуулсны үндсэн дээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт тусгагдах, өөрчлөгдөх шаардлагатай зохицуулалт байж болзошгүй тухай саналаа уг бүтээлд дэвшүүлсэн болно.

### [Түлхүүр үг]

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, Хэргийг прокурорт буцаах, Прокурорт даалгах, Хуулийн үзэл баримтлал.

## I. Оршил

Монгол Улсад хүчин төгөлдөр даган мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг” гэх зохицуулалтыг оруулж ирсэн бөгөөд шүүхийн хэлэлцүүлгийн нэг үе шат болсон юм. Энэхүү зохицуулалт нь хүний эрхийг дээдэлсэн, ардчилсан улсын хуульд тусгагдах зайлшгүй шаардлагатай зохицуулалт мөн бөгөөд тус зохицуулалтыг хуульд тусгасан нь дэвшилтэт алхам болсон гэж судлаачид дүгнэжээ<sup>1</sup>. Монгол Улсын эрүүгийн процессын үеийн хуулиудад шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа гэх зохицуулалтууд агуулагдсаар ирсэн бөгөөд яг тодорхой шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг шиг нэг үе шатыг бий болоогүй байсан юм. Энэ үе шатанд ерөнхий байдлаар тухайн хэргийн бүрдэл хэсэг хангагдсан эсэх, шүүх хуралдааныг үргэлжлүүлэхэд аливаа саад бэрхшээл хэргийн хувьд байгаа эсэх, мөн оролцогчдын эрхийг хангах зэрэг 15 асуудлыг хэлэлцэх боломжтой байдлаар хууль тогтоогч хуульчилжээ.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хууль тогтоомждоо тусгасан нь сайн зүйл болсон боловч тус зохицуулалтын хэрэгжилтийн түвшин болоод үр дагаварын хувьд төдийлөн сайн үр дүн гарахгүй байгаатай холбогдуулан хэд хэдэн асуудлууд хуульч, эрх зүйчдийн дунд практикт тулгарах болсон юм. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх хуралдааны тодорхой нэг үе шат болгон оруулж ирэх болсон хууль тогтоогчдын гол үзэл баримтлал нь гэм буруугийн хэлэлцүүлгийн шатанд хэргийг прокурорт болон мөрдөн байцаалтад буцаах явдлыг халах бөгөөд мөн тус хэлэлцүүлгээр тухайн хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай бэлтгэл хангах ажиллагааг хийж шүүх хуралдаанд бэлтгэх явдал юм. Гэтэл практикт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал дамжин өнгөрөх үе шат болгон зохицуулаагүй бөгөөд талууд болон шүүхийн өөрийн санаачилгаар л хурал зарлах боломжтой байдлаар зохицуулагджээ. Энэ нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдээгүй тохиолдолд эргээд гэм буруугийн шатнаас прокурорт буцах үр дагаварыг бий болгох болжээ. Мөн зарим өмгөөлөгч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн боловч бэлтгэлгүй хийсвэр ярих, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шүүгч өөрийн санаачилгаар шүүхийн хэлэлцүүлгийг зарлахад шүүгчид тус хэргийн хувь заяаг шийдвэрлэх дотоод итгэл бүрдэх бөгөөд гэм буруу хэлэлцэхэд тухайн анхны итгэл үнэмшлээр

---

<sup>1</sup> Должингийн Баярсайхан, *Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, онол практикийн хэлэлцүүлэг, /Илтгэлийн эмхэтгэл/, (Улаанбаатар: 2017)*

хэргийг шийдвэрлэх, тус хэлэлцүүлэгт хийгдэх ажиллагааг шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлэгт давтан шалгах боломжтой буюу давхардуулсан байдлаар прокурорт даалгаж болохоор зохицуулсан зэрэг нь тухайн зохицуулалтын хэрэгжилт болоод үр дагаварт нөлөөлж байна. Иймд практикт тулгамдаж буй эдгээр асуудлыг тодруулж, байж болох сайн гарц гаргалгаа олох үүднээс уг бүтээлийг хийсэн болно.

## II. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үүсэл хөгжил

Англид шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь 12-р зууны үеэс эхтэй бөгөөд энэ нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны нэг хэсэг болж хөгжсөн байна. Тухайлбал, 1554 онд Парламент шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зарим элементүүдийг хуульчилж, шүүхийн шийдвэрийг нээлттэй хуралдаанд гаргах, нотлох баримтыг бичгээр бүртгэх шаардлагыг тогтоож байжээ. Энэ нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн эхлэл байв. Америкийн Нэгдсэн улсад /цаашид АНУ/ 1966 онд “Bail Reform Act” батлагдсанаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ач холбогдол нэмэгдэж, шүүхийн шийдвэрийг шударга, тэгш байлгах зорилгоор шинэчлэлтүүд хийгдсэн байна<sup>2</sup>.

Шударга ёсны тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн хөгжлийн явцад XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед “хэдийгээр шүүх шударга байж болох ч түүнээс өмнөх шатанд гэмт хэргийг шалгаж, мөрдөн нотлох ажиллагаа нь нэг талыг барихгүй, эрүүдэн шүүлт тулгахгүй, зохиомол хилс хэрэг бүрдүүлж, нотлох баримтыг хуурмаглахгүй байх баталгаа, түүний шударга байдлыг хэрхэн хангах вэ” гэсэн асуудал тулгамдсан. Тухайн асуудлыг шийдвэрлэх мөн шударгаар шүүлгэх эрхийн шаардлагын үүднээс “due process” үүсэн бий болсон байна. “Due process” нь хуульд заасан журмаар ажиллагаа явуулаагүй, процессын явцад оролцогчдын эрхийг зөрчсөн бол тухайн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй байх зарчим юм. “Due process”-ийн зөвхөн нэг арга хэрэгсэл бол “шүүхийн өмнөх хэлэлцүүлэг” бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагаа шударга байх явдлыг хангах үүднээс эрүүгийн хэрэг үүсгэх, нотлох баримтыг үнэлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт процессын ажиллагааг алдаагүй явуулах төрөл бүрийн хэлэлцүүлгүүдээс /hearing/ бүрддэг<sup>3</sup>. Орчин үед “Due process”-ийг хангахыг олон

<sup>2</sup> United States Courts, Fedearal Probation URL:[https://www.uscourts.gov/sites/default/files/71\\_2\\_6\\_0.pdf?utm\\_source=com](https://www.uscourts.gov/sites/default/files/71_2_6_0.pdf?utm_source=com), <https://harvardlawreview.org/print/vol-137/bail-at-the-founding/>, [https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein\\_Origins\\_of\\_Public\\_Prosecution\\_at\\_Common\\_Law.pdf?utm\\_source=chatgpt.com](https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein_Origins_of_Public_Prosecution_at_Common_Law.pdf?utm_source=chatgpt.com), (Сүүлд үзсэн огноо: 2025.08.01),

<sup>3</sup> Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлэг, Бодлого судалгааны тайлан”, 2020, 9 дэх тал, [https://forum.mn/uploads/site/1126/res\\_mat/2020/](https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/)

улсын хүний эрхийн байгууллага шаардаж, дэмжиж ирсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын /цаашид НҮБ/ Хүний эрхийн хорооноос илтгэснээр “шүүх ажиллагааны шударга байдал нь шууд болон шууд бус байдлаар хөндлөнгөөс нөлөөлөөгүй байх, ямар нэгэн зорилгоор, аль нэг талаас нэхээгүй, шаардаагүй, дарамтлаагүй, саад болоогүй гэдгээр илэрхийлэгдэнэ” гэжээ<sup>4</sup>. Мөн шударга байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг бол яллах, өмгөөлөх талын хооронд тэгш байдлыг хангах явдал гэсэн байна.

Англи, Америкийн эрх зүйд урьдчилсан хэлэлцүүлэг нь тухайн хэрэгт бичгээр нотлох баримт бүртгэх, шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах журмуудтай уялдсан. Европын бусад орнуудад (Германд, Францад) урьдчилсан хэлэлцүүлэг нь 18-19-р зууны реформын үеэр шүүхийн хяналтын механизмыг сайжруулах, прокурорын үүргийг тодорхойлох зорилгоор хөгжсөн.

Дэлхийн Эрүүгийн процессын загвар хууль /2008/-д Монгол улс нэгдэж ороогүй ч гэсэн нийтлэг жишиг түгээмэл хандлагыг баримталбал зохих бөгөөд уг хууль 17 хэсэг, 346 зүйл, 420 тайлбартай. Тухайн хуулийн гол зорилго нь социалист тогтолцооны дараах болон шилжилтийн үеийг даван туулж буй улс, орнуудад эрүүгийн процессын хуулиа шинээр гаргах, шинэчлэн өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэхүйц үзэл баримтлал, суурь зарчмыг тодорхойлж, үлгэрчилсэн хуулийн хэв маяг, эх сурвалжийг гаргахад чиглэгдсэн. Тус загвар хуульд өндөр хөгжилтэй орон болон аль нэг систем, тогтолцооны шинжийг чухалчлан тусгаагүй, харин дундын буюу хосолсон зохицуулалт бүхий дэлхий нийтийн орчин үеийн түгээмэл хандлагыг тусгаснаараа ач холбогдолтой баримт бичиг болсон хэмээн судлаачид үздэг<sup>5</sup>. Эрүүгийн загвар хуулийн 3 дугаар хэсгийн 228-238 дугаар зүйлд, нотлох баримтын дүрэм, стандарт болон эрүүгийн хэргийн талаарх мэдээлэл, баримт сэлтийг нотлох баримтад тооцох шалгуур, нөхцөл журмыг тусган оруулжээ. Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөхүйц, эргэлзээгүй байдлыг хангах, шууд хамааралгүй буюу давхардсан эсвэл дамжмал хамаарал бүхий баримт сэлтүүдийг нотлох баримтаас хасах, харилцан яриаг нотлох баримтад тооцохгүй байх зэрэг нөхцлүүдийг нарийвчлан зааж, тайлбартайгаар тодорхойлжээ. Шүүх дээр нэмэлт нотлох баримт гаргах нөхцөл боломжийг хуульчилж, яллах нотлох баримт бүхий хавтаст хэргийг шүүхэд шилжүүлэхийг хязгаарлаж, шүүхэд шилжүүлэхийн өмнөх шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал хийх, шүүх хуралдааныг шударгаар, эрх тэгш байдлыг хангаж

---

*ErkhZuinemkhetgel.pdf*, (Сүүлд үзсэн: 2024.03.01).

<sup>4</sup> Хүний эрхийн хороо, 32-р ерөнхий зөвлөмж, 25-р догол мөр /дам эшлэв/.

<sup>5</sup> Должингийн Баярсайхан, *Гадаад орнуудын эрүүгийн процесс*, (Улаанбаатар: Мөнхийн үеэг, 2015), 19 дэх тал.

явуулах зэрэг нийтлэг агуулгыг тусгасан бөгөөд мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр тогтоогоогүй баримтаар гэм буруутай гэж ял тулгаж харьцахгүй байх байна.<sup>6</sup>

Монгол улсын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь цоо шинэ ойлголт биш бөгөөд 1949, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ажиллагаа нь “бэлтгэл цуглаан” гэсэн нэртэй байсан. 1949 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ гэх)-иар прокуророос ял төлөвлөж ирүүлсэн бүх хэргийг шүүхэд шилжүүлэх асуудлыг нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй бэлтгэл цуглаанаар хэлэлцдэг байсан бол 1963 оны ЭБШХ-иар ялын төлөвлөгөөний дүгнэлт болон гэмт хэрэгт оногдуулсан эрүүгийн хуулийн зүйл, ангийг зөвшөөрөхгүй, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх шаардлагатай байвал нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй захиран тушаах хурлаар хэлэлцэж, бусад тохиолдолд яллагдагчийг шүүгчийн тогтоолоор шүүхэд шилжүүлэхээр зааж байжээ. (ЭБШХ, 1963 он. III хэсэг, 24 дүгээр бүлэг 219-237 дугаар зүйл)<sup>7</sup>.

Бэлтгэл цуглаанаар дараах асуудлыг шийддэг байжээ. Үүнд:

- Шүүгч хэргийг ялын төлөвлөгөөний хамт прокуророос хүлээн авмагц “бэлтгэл цуглаан”-аар хянан хэлэлцүүлэхээр оруулах ёстой байсан бол яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг хэрэг хүлээн авснаас хойш шүүгчийн тогтоолоор 7 хоногийн дотор, захиран тушаах хурлаар 10 хоногийн дотор шийдвэрлэх (ЭБШХ, 1963 он. 219-221 дүгээр зүйл);

- “Бэлтгэл цуглаан”-д хэргийн талаар прокурор илтгэгчээр оролцох буюу мөрдөн байцаагчийг бэлтгэл цуглаанд оролцуулах бөгөөд илтгэгчээр томилон явуулах эрхтэй байсан бол захиран тушаах хуралд шүүгч ялын төлөвлөгөөний дүгнэлтүүд, хуулийн зүйл, анги, таслан сэргийлэх арга хэмжээг зөвшөөрөхгүй байгаа үндэслэлийн талаар илтгэж, мөн холбогдох байгууллага, хүмүүсийн гаргасан хүсэлт, прокурорын дүгнэлтийг сонсож зөвлөлдөх тасалгаанд магадлал гаргах журмаар шийдвэрлэх;

- Яллагдагч оргон зайлсан, оршин суугаа газар нь мэдэгдэхгүй байвал түүнийг олдох хүртэл, түүнчлэн яллагдагч сэтгэл мэдрэлийн буюу бусад хүнд өвчний улмаас шүүх хуралд оролцох бололцоогүй нь эмнэлгийн байгууллагад ажиллаж байгаа их эмчийн магадлагаагаар нотлогдож байвал эдгэртэл нь шүүх хурлыг түдгэлзүүлэх, уг хэрэг өөр шүүхэд харьяалагдахаар байвал харьяаллын дагуу шилжүүлэх;

<sup>6</sup> Должигийн Баярсайхан, *өмнөх эшлэл 5*, 19-20 дахь тал.

<sup>7</sup> ХЗҮХ, ХЗДХЯ, “*Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2011 он*”, 2012.

- Урьдчилсан мөрдөн байцаалт бүрэн биш бөгөөд тэр нь шүүх хурлаар нөхөн гүйцэтгэх бололцоогүй, хэрэг бүртгэх буюу урьдчилсан мөрдөн байцаалт явуулах үед эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, урьд сонгосон ял дээр нэмж ял сонгох, эсхүл ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаар нь ялын төлөвлөгөөнд дурдсанаас онцын ялгаатай болгон өөрчлөх үндэстэй, уг хэрэгт өөр хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах үндэстэй бөгөөд тэдний материалыг хэргээс тусгаарлах боломжгүй, хэргийг буруугаар тусгаарласан буюу нэгтгэсэн бол нэмж мөрдөн байцаалт явуулахаар хэргийг прокурорт буцаах;

- Хуульд заасан үндэслэл байвал хэргийг хэрэгсэхгүй болгохоор тус тус заажээ<sup>8</sup>.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд /ЭХХШТХ/, шүүхийн гэм буруугийн хуралдаанаас прокурорт буцаах зохицуулалтыг хүчингүй болгож, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх /цаашид ШУХ/ зохицуулалтын ЭХХШТХ-д VII хэсэг 33 дугаар бүлэгт “Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа” нэршилтэйгээр оруулж ирсэн.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргахаар зохицуулсан байна. Тодруулбал:

- Өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;
- Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт;
- Эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол, нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;
- Прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;
- Яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;
- Шүүх хуралдааныг хялбаршуулж явуулах тухай хүсэлт;
- Яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;
- Яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;
- Шүүх хуралдааны товын талаарх санал, хүсэлт;
- Шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх прокурор, оролцогчийн санал,

---

<sup>8</sup> Нээлттэй нийгэм форум, өмнөх эшлэл 3, 14 дэх тал.

хүсэлт;

- Шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;
- Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;
- Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;
- Мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;
- Хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;
- Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.

Мөн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт “Урьдчилсан хэлэлцүүлгээр энэ зүйлийн 6.13, 6.14, 6.15, 6.16-д заасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй бол хэлэлцэхгүй орхиж, анхан шатны шүүх хуралдаанаар уг гомдол, хүсэлтийг шийдвэрлэнэ.” гэсэн зохицуулалт үйлчилж байсан, тодруулбал тухайн тохиолдолд шүүх хуралдаанаас прокурорт хэргийг буцааж болохоор байжээ.

Дээрхээс үзвэл манай улсад 2017 онд Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалт цоо шинээр орж ирсэн бөгөөд гэм буруугийн шатнаас прокурорт хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаахаас урьдчилан сэргийлж, талуудыг идэвхжүүлэх, зөвхөн энэ шатанд цугларсан нотлох баримтын хүрээнд, гэм бурууг эцэслэн тогтоож шийдвэрлэх үзэл баримтлалтайгаар орж ирсэн зохицуулалт болно.

Энэ 2017 оны ЭХХШТХ-ийн өөрчлөлтөөрөө Монгол улс бол шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах /инквизици- Investigation process/, шүүхийн шатанд мэтгэлцэх /аккусац- Accusatory process/ буюу холимог буюу хосолсон /Equivocasy and mixed process/ хагас нээлттэй зарчмыг тунхагласан эрх зүйн орчин бүрдсэн байна<sup>9</sup>. ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.15 дугаар зүйлд зааснаар нэмж, нэмэлт ажиллагаа хийлгэхээр, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шийдвэрлэх болсон нь гэм буруугийн хэлэлцүүлэгт прокурорт буцаах үр дагавраас сэргийлэх зорилготой болно. Тодруулбал ЭХХШТХ-н 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй.” гэж заасан. Хэргийг буруу тусгаарласан, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу

<sup>9</sup> Должингийн Баярсайхан, “Эрүүгийн процессын эрх зүйн зарим тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг, 2017.12.08, <https://www.youtube.com/watch?v=WUyGi8lSV9o&t=1966s>.

хийгдсэн ба шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШТХ-г ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн алдаа гарсан тохиолдолд ЭХХШТХ-н 33.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 33.3 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд нэг удаа шүүгч хэргийг прокурорт буцаах боломжтой болсон.

*“Шинэчилсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн чухамхүү нэг гол үзэл баримтлал нь шүүхийн хэлэлцүүлгийн үе шатыг хоёр хувааж шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, гэм буруугийн шүүх хуралдаан гэж зааглаж салгасан”*

Заагласны мөн чанар, зорилго, агуулга нь Эрүүгийн процессын үндсэн «оролцогчид» болох мөрдөгч, прокурор, шүүгч нарт яллах ба цагаатгах нотлох баримтыг бүгдийг тэгш цуглуулах, үнэлэх, аль нэг талыг хэт баримталж, давуу байдлыг олгохгүйгээр шүүх хуралдаанд талууд мэтгэлцэхийг ЭХХША-ны суурь зарчим болгож хуульчилсан. Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд үндэслэсэн ЭХХШТХ-н зарчмуудыг бүхэлд нь дүгнэвэл “Нотол. Нотолж чадахгүй бол цагаатга” гэх зарчмыг манай улс үндэсний хууль тогтоомждоо нутагшуулсаар ирсэн байна. Үүнийг “Нэг гэмгүй хүнийг хилсээр ялласанд орвол зуун гэмт хэрэгтнийг сулла” гэдэг хэлц үгээр ч илэрхийлсэн нь байдаг.

Дээрхээс үзвэл өмгөөлөгчийн явуулах үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, оролцоог өргөжүүлэхээр шинэчлэлтэд тусгасан. Тухайлбал, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мөрдөн шалгах ажиллагааны явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх тухай хүсэлт зэрэг 17 үндэслэлээр хэлэлцэж, урьдчилсан хэлэлцүүлгээс хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаах шийдвэр гаргуулж болохоор заасан. Мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед өмгөөлөгчөөс гаргасан шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаарх санал, хүсэлтийг шүүх хангахаар тусгасан.

### **III. Практикт тулгамдаж буй асуудал**

Практикт шүүхийн хэлэлцүүлгийн нэг үе шатад тооцогдох үе шат маань бүрэн дүүрэн хэрэгжихэд дараах бэрхшээлүүд тулгарч буй юм. Үүнд:

- Өмгөөлөгч хүрэлцэн ирдэггүй. /ЭХХШТХ, 33.1-8/

Өмгөөлөгч шүүх хуралдаанд идэвхгүй байр суурьтай оролцдог. Тодруулбал “Өмгөөлөгч оролцохгүй байх нь ШУХ явуулахгүй байх үндэслэл болохгүй гэж зохицуулсан”

• Өмгөөлөгч хүрэлцэн ирсэн боловч, чухал хэлэлцэгдэх нотлогдоогүй, нотлох баримтын зөрүү, нотлох баримтын харьцуулан шалгах ажиллагааг бэлтгэлгүй хийсвэр ярьдаг.

*“Хавтаст хэрэгт огт дурдагдаагүй хүнээс гэрчийн мэдүүлэг авах шаардлагатай байсан”* ямар үндэслэлээр, хэний мэдүүлэгт гарснаар, юуг нотлоход чухал ач холбогдолтой гэж үзэж байгаагаа хэлдэггүй. Тодруулбал нотолбол зохих байдлын хүрээнд нотлогдоогүй зарим байдал, нотлох баримтын ноцтой зөрүүтэй байдлыг, холбогдох нотлох баримтыг харьцуулах, шалгах ажиллагаа огт хийгдэхгүй зөвхөн хийсвэр байдлаар ярих, тайлбарлах нь хангалтгүй байдаг<sup>10</sup>. *Нийт хэргийн бараг 60 орчим хувь нь өмгөөлөгчгүй буюу ЭХХШтХ-н 5.3 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр ЭХХША-г явуулж байна*<sup>11</sup>

2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тохиолдолд зайлшгүй өмгөөлөгч авах зохицуулалт орсон нь цаашдаа өмгөөлөгчийн байр суурийг өргөжүүлэх чиглэлд хөгжиж байна гэж үзсэн боловч 2025 оны байдлаар хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боловч шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлэгт өмгөөлөгч хүрэлцэн ирэхгүй байсан ч шүүгдэгчийн хүсэлтээр шүүх хуралдаанд өөрөө, өөрийгөө өмгөөлж оролцох тохиолдол их гарах болсон<sup>12</sup>.

• Шүүх өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг товлож болохоор зохицуулсан /ЭХХШтХ 33.1-6 /

Өнөөгийн практикт урьдчилсан хэлэлцүүлгээр мөрдөн шалгах болон нотлох баримт цуглуулж, бүрдүүлсэн ажиллагааг түүнчлэн прокурорын хяналтыг бүхэлд нь шүүхээр шалгах агуулгаар гэм буруугийн шийдвэр гаргах эрхтэй шүүгчид урьдчилсан хэлэлцүүлгийг удирдаж, хэргийн материалтай урьдчилан танилцах бололцоо олгосноор шүүгчид гарцаагүй урьдчилан дүгнэлт хийх, бүхнийг “төгс мэдэх” нөхцлийг бүрдүүлж, талуудыг мэтгэлцээний үр дүнд бус урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнд дотоод итгэл үнэмшил бүрдэх нөхцөлийг бий болгожээ<sup>13</sup>. Өмгөөлөгч идэвх сул оролцох нь шүүх прокурорын ажлыг хянах чиг үүрэгтэй оролцох бөгөөд

<sup>10</sup> Шүүх хуралдааны урьдчилсан хэлэлцүүлэгт сууж ажиглалт хийсэн, хуульчдаас асуулгын аргаар судалсан.

<sup>11</sup> Нээлттэй нийгэм форум, *Өмнөх эшлэл 3*, 35 дахь тал.

<sup>12</sup> Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн практикаас, (Улаанбаатар: 2025)

<sup>13</sup> Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, *“Шүүхээс хэргийг буцаах нь зайлиггүй асуудал уу?, эрдэм шинжилгээний өгүүлэл”*, Эрх зүй, 51 (3), 2020, 373 дахь тал.

тэр нотлох баримт дутуу, энэ хэргийг нотлох энэ баримт нотлох баримтын шаардлага хангаагүй зэрэг яллах байр сууриас хэрэгт хандаж мэтгэлцэх зарчим зөрчигдөх болсон. Эргээд тус хэргийг шийдвэрлэхэд шүүгчийн хүссэн нотлох баримтыг прокурор бүрэн гүйцэтгэлтэй хангаж орж ирснээрээ шүүх, прокурор гэх тус тус чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага нэг зорилгод оршин буй илрэл болж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал хийхээр хуульчлаагүй.

/ЭХХШТХ 33.1-4/

Тусгайлсан энэ үе шатыг шинээр оруулж ирээд, энэ үе шатанд л гэм буруугийн шатанд хэлэлцэгдэх хэргийн нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоосон эсэхийг хэлэлцэх үзэл санаагаар хуульчлагдсан боловч заавал хэлэлцүүлэг хийхээр зохицуулаагүй нь анхаарах асуудал юм. Үүнээс үүдэн зарим анхан шатны эрүүгийн шүүхийн хувьд ял завшуулахгүй байх үүднээс хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж, зарим нь хэргийг цагаатгаж шийдвэрлэх бөгөөд цагаатгасан хэргийн тухайд дээд шатны шүүхээс хэргийг хүчингүй болгож<sup>14</sup> дахин хэлэлцүүлэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь цаг хугацааны хувьд болоод шүүгдэгчийн хувьд эрүүдэн шүүлт болж хохирогчийн хувьд сэтгэл санааны дарамтад байх боломжийг олгож байна.

- Зарим зохицуулалтыг давхардуулсан

/ЭХХШТХ 34.16-6/

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд 15 үндэслэлээр бэлтгэл хангах ажиллагаа хийлгэх эрх нээлттэй байдлаар зохицуулсан. Эдгээр хуульд заасан ажиллагаа хийлгэх үндэслэлд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол гэж тусгасан бөгөөд шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлэгт мөн дээрх үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах талаар дахин зохицуулсан нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хүчийг сулруулж байна. Өмгөөлөгч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт идэвхгүй оролцож, эргээд хуралдааныг хойшлуулах боломжтой гэж хандах өнцгийг бий болгож байна.

Баянзүрх дүүргийн прокурорын газраас, шүүхээс прокурорт

---

<sup>14</sup> Улсын Дээд шүүхийн шүүгч Батаагийн Батцэрэн., Хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх үндэслэл болохгүй, 2023, URL:<https://legaldata.mn/shiidver/huraangui/view/174>

хэргийг буцаасан шалтгаан нөхцөлийг 2022 оны 4 дүгээр улирлын судалгаа хийгдсэн байна. /2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд/<sup>15</sup> Судалгаа хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдсон байна. Үүнд:

Дээрх хугацаанд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн хэргээс анхан шатны шүүхээр 894 хэрэг, давж заалдах шатны шүүхээр 94 хэрэг, хяналтын шатны шүүхээр 5 хэрэг, нийт 993 хэрэг шүүхээр хянан хэлэлцэгдсэн ба судалгаанд хамрагдах хугацаанд нийт 33 хэрэг буюу 4 хувь нь прокурорт буцаж шийдвэрлэгдсэн байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх болсон үндэслэлээр авч үзвэл, шүүхийн санаачилгаар 9, яллагдагч болон яллагдагчийн өмгөөлөгчийн хүсэлтээр 17, хохирогчийн төлөөлөгчийн гаргасан хүсэлтээр 1 хэрэг байна. ШУХ-н ололттой ба дутагдалтай талууд юунд байгааг олж тогтоон цаашид энэ талаар авах арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлох зорилгоор ярилцлагын судалгааг явуулсан байна<sup>16</sup>. Судалгаанд оролцогчдын 49 хувь нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцээний хэлбэрийг ягштал баримтлах явдал хэвшил болон төлөвшиж чадсан. Мэтгэлцээний хэрэгжилт бүрэн бус байна гэж, судалгаанд оролцсон прокуроруудын 50 хувь, харин өмгөөлөгчдийн 50.6 хувь нь дүгнэсэн байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хэлэлцэгдсэн асуудлаар нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг прокурорт буцаасан боловч, гүйцэтгэхгүйгээр эсхүл бүрэн бус дутуу гэм буруугийн хэлэлцүүлгийн шатанд орж ирсэн тул дахин 60 хоногийн зохицуулалтаар давтан даалгах үр дагаварт хүргэсэн байна. Тодруулбал БЗД-н Прокурорын газрын 4-р улирлын, шүүхээс прокурорт хэрэг буцах судалгаанаас үзэхэд захирамжид заасан ажлыг дутуу гүйцэтгэсэн үндэслэлээр, шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлгээс буцсан хэргийг тусгайлан нэг үндэслэл болгон судалгаа хийгдсэн байна.

Дээрхээс дүгнэвэл Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс прокурорт буцсан нийт 14 хэргээс 10 нь ЭХХШТХ-ийн 16.2 дугаар зүйлд заасан “Нотолбол зохих байдал” бүрэн хангагдаагүйтэй холбоотойгоор прокурорт буцсан бол “Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчсөн” үндэслэлээр 1 хэрэгт, “Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн” үндэслэлээр 2 хэрэгт, “Зүйлчлэлийг өөрчлөх” үндэслэлээр 1 хэрэгт прокурорт буцааж шийдвэрлэсэн байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хийх санаачилгаар хоёр дахь байрыг шүүх эзлэх бөгөөд шүүх өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зарлах нь яллах

<sup>15</sup> Баянзүрх дүүргийн прокурорын газарт, улирал бүр тогтмол судалгаа шинжилгээ хийгдэж, үр дүнд үндэслэн мэргэжлийн арга зүйн зөвлөгөөг хүргэдэг байна.

<sup>16</sup> Нээлттэй нийгэм форум, *өмнөх эшлэл* 3, 35 дахь тал.

шүүхийн хэв шинжийг агуулж байна гэж үзэх үндэслэлтэй. Нотлох баримтын бүрдэл дутууг гүйцээх тухайд шүүхээс чиглэл өгч гэм буруугийн хэлэлцүүлэгт прокурорт шүүгчийн зааврыг гүйцэтгэж орж ирснээрээ бие биенээсээ үл хамааралтай байх бүтэц зөрчигдөж, шүүх яллах нь гарцаагүй зүйл болсон юм. Тухайн зохицуулалтыг давхардуулж хууль тогтоомжид тусгагдсан тухайд прокурорт даалгаж шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалтыг урдаа барьж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдээгүй тул энэхүү боломжоор хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж байна.

#### **IV. Гадаад орнуудын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн ижил болон ялгаатай байдал,**

Дэлхийн орнуудын эрх зүйн тогтолцоо нь тухайн улсын үндэсний ёс заншил, соёл, нийгмийн харилцааны хөгжил, онцлогийг тусгахаас гадна олон улсын эрх зүйн системийн хэв маяг, нийтлэг жишиг, чиг хандлагыг харгалзан хөгжсөн байдаг<sup>17</sup>. Харьцуулсан эрх зүйн судлалыг үндэслэгчдийн нэг Францын судлаач А.Леви-Ульманы ангиллаар дараах байдлаар ангилсан байна. Үүнд:<sup>18</sup>

Англи-Америкийн, /Англи, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд,/

Эх газрын, /Итали, Португаль, Франц, Герман, Грек, Турк/

Мусульманы, /Иран, Саудын Араб, Афганистан, Ирак, Катар, /

Хосолсон ба холимог эрүүгийн, /БНХАУ, Япон, Филиппин, ОХУ/ гэх мэт. Иймд дээрх ангиллын хүрээнд тогтолцоо бүрийн харилцан онцлогийг харгалзаж, Англи-Америк, Эх газрын, Хосолсон буюу холимог тогтолцооноос дараах улсуудыг сонгож харьцууллаа.

А. Оросын Холбооны улс<sup>19</sup>

Оросын Холбооны Улсын /цаашид ОХУ/ хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь холбооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгэн адил үйлчилдгээрээ бусад холбооны улсуудаас ялгаатай ба Ром-Германы эрх зүйн бүлд хамаардаг. Мөн ОХУ-ын дээд шүүхийн бүгд хурлын удирдамж, хууль тайлбарласан акт, албан ёсоор нэгтгэн дүгнэсэн шүүхийн практик нь хууль тогтоомжийг хэрэглэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг. ОХУ-д шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн шүүгчдээс гадна тангарагтны 9 төлөөлөгч оролцдог. Тангарагтны төлөөлөгч нь ОХУ-

<sup>17</sup> Должингийн Баярсайхан, *Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, онол практикийн хэлэлцүүлэг*, /Илтгэлийн эмхэтгэл, “Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага”.

<sup>18</sup> Должингийн Баярсайхан, *Харьцуулсан эрүүгийн эрх зүй*, (2 дахь хэвлэл) (Улаанбаатар: Соёмбо, 2012), 40 дэх тал.

<sup>19</sup> Нээлттэй нийгэм форум, *өмнөх шилэл* 3, 25-26 дахь тал.

ын иргэн байх бөгөөд тангарагтны төлөөлөгчийн жагсаалтад орсон, хуулиар тогтоосон журмын дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох боломжтой байна.

ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2001 оны 12-р сарын 18-ны өдөр батлагдаж, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Энэ хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаар 34-р бүлгийн 234-239-р зүйлд анх тусгаж өгсөн байна. Энэхүү хуулиар шүүх талуудын хүсэлтээр, эсвэл өөрийн санаачилгаар дараах тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг хийхээр тусгасан. Үүнд: Яллагдагчид яллах дүгнэлтийг гардуулснаас хойш долоо хоногийн дотор эрүүгийн хэргийн материалыг уншиж танилцуулсны дараа буюу эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага, хэрэг бүртгэгч хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж бэхжүүлсэн нотлох баримт нь нотлох хүчин чадлаа алддаг. Хуульд заасан шаардлагыг зөрчиж олж авсан нотлох баримт нь хүчин төгөлдөр бус бөгөөд аливаа нөхцөл байдлыг нотлоход ашиглах яллах үндэслэл болдоггүй төдийгүй хэргийн ямар ч нөхцөл байдлыг нотлох үндэслэл болохгүй байхаар заасан.

Холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөөгүй нотолгоо нь дараах зүйлийг агуулна. Үүнд: сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчгүй явуулсан мөрдөн шалгах ажиллагаа, өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдолд өмгөөлөгчтэй явуулахаар заасан ажиллагааг өмгөөлөгчгүй явуулсан, тухайн ажиллагааг өмгөөлөгчгүй явуулсныг сэжигтэн яллагдагч баталгаажуулаагүй бол; гэрч, хохирогч өөрийн таамаглал, дам сонссон ярианд үндэслэн мэдүүлэг өгсөн, мэдүүлгийн эх сурвалжаа тодорхой заагаагүй, хуулийн шаардлагыг зөрчиж мэдүүлсэн тохиолдолд нотлох баримтад тооцогдохгүй. Талуудын аль нэг нь нотлох баримтыг хүчингүйд тооцохыг эсэргүүцэж байгаа бол шүүгч эрүүгийн хэрэгт байгаа мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл болон бусад баримт бичгийг нөгөө талд танилцуулах эрхтэй. Өмгөөлөгчийн зүгээс хуульд заасан шаардлагыг зөрчиж бэхжүүлсэн нотлох баримтыг хүчингүйд болгох хүсэлт гаргасан тохиолдолд прокурор түүнийг бусад баримт сэлтийг няцаах үүрэгтэй. Харин хэрэгт авагдаагүй баримт сэлтийг үндэслэж нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлт гаргаж байгаа тохиолдолд түүнтэй холбоотой нотлох баримтыг өмгөөлөгч өөрөө гаргаж өгөх үүрэгтэй. Хэрэв шүүгч нотлох баримтыг хүчингүйд тооцуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байгаа бол шүүх ямар нотлох баримтыг хүчингүйд тооцож байгаа, хүчингүйд тооцох болсон

үндэслэл, шүүх хуралдаан дээр тухайн нотлох баримтыг танилцуулах, шинжлэн судлахыг хориглосон тухай тогтоол гаргана.

Шүүгч талуудын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулж дараах тохиолдолд шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаана. Үүнд: Яллах дүгнэлт болон ялын санал нь хуулийн шаардлагад нийцээгүй, яллах дүгнэлт болон ялын саналыг яллагдагчид гардуулаагүй, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах үндэслэлтэй хэрэгт яллах дүгнэлт болон ялын саналд энэ тухай тусгаагүй, эдгээр тохиолдолд шүүгч гаргасан зөрчлийг 5 хоногийн дотор арилгахыг прокурорт үүрэг болгох ба ингэхдээ шүүгдэгчид оногдуулсан таслан сэргийлэх арга хэмжээг мөн шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл байвал шүүх урьдчилсан хэлэлцүүлэг явуулна. Шүүгч дараах тохиолдолд эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана. Үүнд: яллагдагч оргон зайлсан, хаана байгаа нь тодорхойгүй;

- яллагдагч хүнд өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр нотлогдсон;
- тухайн хэрэгт хэрэглэгдэх хуулийн талаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргасан;
- яллагдагчийн хаана байгаа нь тодорхой боловч шүүх хуралдаанд оролцох боломжгүй.
- Шүүгч дараах тохиолдолд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана. Үүнд:
  - хөөн хэлэлцэх хугацаа дууссан;
  - яллагдагч нас барсан;
  - гомдлоор үүсгэх эрүүгийн хэрэгт хохирогч гомдол гаргахаас татгалзсан;
  - хэрэг хариуцах чадваргүй этгээдээс гомдол гаргасан;
  - эрүүгийн хэрэг үүсгэх, эсвэл яллагдагчаар татахаас шүүх татгалзсан бол;
  - прокурор яллахаас татгалзсан;
  - талууд эвлэрсэн;
  - цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас гэмт хэргийн нийгэмд аюултай шинж чанар үгүйсгэгдсэн;
  - талуудын аль нэгний хүсэлтээр идэвхтэй гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн зэрэг үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож болно.

Урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнд шүүгч эрүүгийн хэргийн харьяаллыг тогтоох, прокурорт буцаах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох, шүүх

хуралдааныг товыг тогтоох тухай шийдвэрийн аль нэгийг гаргана. ОХУ-н Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 237 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтөөр мөрдөн шалгах ажиллагааны дутууг нөхөж, гүйцээлгэх зорилгоор буцааж байсныг бүрмөсөн болиулж, шүүхээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж буй нөхцөл байдлыг арилгуулах зорилгоор хэргийг прокурорт буцаах боломжийг хуульчилсан байна. Ингэхдээ 2 тохиолдлыг хуульчилсан байна. Үүнд:

- Хэргийг шүүхэд шилжүүлсний дараа яллагдагчид аюултай шинэ үр дагавар үүсэж, түүнд нь илүү хүнд ял сонсгох шаардлагатай болсон.

- Эрүүгийн хэргийн талаар өмнө гаргасан шүүхийн тогтоол, магадлал, захирамжийг дээд шатны шүүхээр хүчингүй болгосон бөгөөд хүчингүй болгох шийдвэрийн үндэс болсон шинэ болон дахин үүссэн нөхцөл байдал нь яллагдагчид илүү хүнд ял сонсгох болсон<sup>20</sup>.

Шүүх бүрэлдэхүүн ял оноох бүрэн үндэслэлтэй гэж үзвэл шүүхийн яллан шийтгэх тогтоол гарна. Хэрэв үндэслэлгүй буюу нотлогдоогүй гэж үзвэл шүүхийн цагаатгах буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол гаргана. Харин анхан шатны шүүх хуралдаанаар бүрэн хэлэлцээний дараа прокурор эсхүл мөрдөн байцаалт руу буцаах шийдвэр гаргахгүй<sup>21</sup>. Давж заалдах болон хяналтын шатны шүүх эрүүгийн хэргийг прокурор болон доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээ эдэлдэг. Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түүхэн уламжлал нь ОХУ-ын нөлөөгөөр хөгжиж ирсэн бөгөөд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зарим зохицуулалтын хувьд ойролцоо, ижил төстэй зүйл, хэсгийг харьцуулан судлах, манай улсын хууль тогтоомжид байхгүй дэвшилтэт шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлэх боломжтой болно.

УПК РФ-ийн 34-р бүлэгт (Глава 34)<sup>22</sup> Статья 234. Урьдчилсан хэлэлцүүлгийн журам

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч ганцаарчилсан, хаалттай хуралдаанаар явуулах бөгөөд талууд оролцоно. Оролцогч талуудад хуралдаанд оролцох тухай хамгийн багадаа 3 хоногийн өмнө мэдэгдэх ёстой. Хэрвээ яллагдагч хүсэлт гаргасан бол тус хуралдаанд оролцох боломжтой байна. Прокурор, шүүгдэгчийн өмгөөлөгч ирснээр шүүхийн хэлэлцүүлгийг ирц бүрдэх бөгөөд, ирээгүй нь хэлэлцүүлгийг зогсоох үндэслэл болдоггүй байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг (предварительное судебное

<sup>20</sup> Консультант Плюс, “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174 ф3, URL: [https://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_34481/](https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/), (дата обращения: 2024.03.01)

<sup>21</sup> Должингийн Баярсайхан, *Өмнөх жилэл 5*, 115 дахь тал.

<sup>22</sup> Уголовно-процессуальный кодекс РФ 2025

слушание) зарим тохиолдолд хэрэглэгддэг, гэхдээ заавал хийх ёстой гэж хуульчлаагүй байна. Тус улсын шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд шүүгдэгчийн өмгөөлөгчөөс нотлох баримт хасуулах тухай хүсэлт гаргахад яллах талаас эсэргүйцээгүй тохиолдолд хүсэлтийг хангаж шийдвэрлэдэг байна. Тодруулбал мөн хуулийн статья 235. Нотлох баримтыг хасуулах тухай хүсэлтийн талаар зохицуулсан бөгөөд хоёр талаас хүсэлт гаргах эрх эдлэх ба хүсэлтийн хуулбарыг нөгөө талд тухайн өдөр нь олгоно. Хүсэлт нь дараах зүйлийг заавал агуулна. Үүнд:

- Хасуулахыг хүссэн нотолгооны тодорхойлолт,
- Хасах үндэслэл (УПК РФ-д заасан) болон түүнд холбогдох тайлбар,
- Шүүгч гэрч дуудаж, баримтыг хэрэгт хавсаргах боломжтой.
- Нөгөө тал эсэргүүцэж байвал шүүгч холбогдох материалуудыг унших боломжтой.
- Хэрэв шүүгдэгчийн өмгөөлөгч нотолгоог хууль зөрчин авсан гэж үзвэл, нотлохын хариуцлага прокурорт (зохих хариу баримтаа нотлох буюу нотлогооны хувиарлалт)
- Өөр тохиолдолд хүсэлт гаргасан тал хариуцна.

Статья 236. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнд гарах шийдвэрүүдийг хуульчилсан байна. Үүнд:

- Хэргийг прокурорт буцаах;
- Хэргийг түр зогсоох;
- Хэргийг таслан зогсоох;
- Шүүх хуралдааныг товлох;

Статья 237. Шүүхээс хэргийг прокурорт буцаах нөхцлүүдийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- Хууль зөрчсөн шийтгэлийн акт;
- Яллагдагч өмгөөлөх авах хүсэлттэй боловч өмгөөлөгч аваагүй,
- Эмчилгээ шаардлагатай;
- Хэд хэдэн хэрэг нэгтгэх шаардлага гарсан,
- Яллагдагчид, түүний эрхийг тайлбарлаагүй;
- Шинээр илэрсэн нөхцөл байдлаас илүү хүнд ял шийтгэлийг шаардсан гэх мэт. Хэрэв прокурорт хэрэг буцсан тохиолдолд яллагдагчид шүүхээс таслан сэргийлэх арга хэмжээ авч шийдвэрлэдэг байна.

Статья 238-239.2 Бусад холбогдох зүйлийг үүнд зохицуулсан ба хэрэг түр зогсоох, яллагдагч ор сураггүй болсон, хүнд өвчин туссан, Үндсэн хуулийн шүүхэд хандсан, яллагдагч шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон зэрэг тохиолдолд прокурорт даалгавар өгч даалгаж шийдвэрлэдэг байна.

УПК РФ-д шүүхийн урьдчилсан шат буюу урьдчилсан хэлэлцүүлгээс эсвэл үндсэн шүүх хуралдаанаас прокурорт хэрэг даалгах заалт бий. УПК РФ-ийн 34-р бүлэг (Ст.234–237)-д зааснаар: Урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр шүүх хэрэгт нотлох баримт дутагдалтай, эрх зөрчигдсөн эсвэл хууль зөрчсөн тохиолдолд хэргийг прокурорт буцааж болно. Үндсэн буюу гэм бурууг хэлэлцэх үед (Ст.237, 307–308) Хэрвээ шинээр илэрсэн нотолгоо, хууль зөрчсөн үйлдэл, эсвэл яллагдагчийн эрх ноцтой зөрчигдсөн бол шүүх хэргийг прокурорт буцаах эрхтэй. Энэ нь хэрэг урьдчилсан шатнаас дамжин үндсэн хэлэлцүүлэгт орсны дараа дахин буцаагдаж болно гэсэн үг.

Дээрхээс үзэхэд прокурорт буцаах зохицуулалт энэ улсад үйлчилдэг бөгөөд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон зарим тохиолдолд шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлгээс ч прокурорт хэрэг буцах мөн даалгах зохицуулалт байдаг байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх өөрийн санаачилгаар хэлэлцүүлэх боломжтой байдлаар мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал хийхээр хуульчилж өгөөгүй нь Монгол улстай ижил зохицуулалт үйлчилдэг байна. Тус улсад прокурорт даалгах зохицуулалт байдаг бөгөөд хэргийг прокурорт буцаах зохицуулалт ч мөн давхар хэрэгждэг байна.

Б. Америкийн Нэгдсэн улс<sup>23</sup>

Америкийн Нэгдсэн улсын /цаашид АНУ/ хувьд мөн адил холбооны улс боловч шүүхийн тогтолцоо нь Холбооны Бүгд Найрамдах Герман улсаас /цаашид ХБНГУ/ зарим зүйлээр ялгаатай. Холбооны анхан /district court/, давах /appeal court/, хяналтын шатны /Federal Supreme Court/ шүүхийн зэрэгцээ муж бүрд мужийн хуулийн дагуу гурван шатны шүүх үйл ажиллагаа явуулдаг.

АНУ-ын дүрмүүд нь анх 1945 оны 3 дугаар сард хүчин төгөлдөр болсон бөгөөд хамгийн сүүлийн нэмэлт, өөрчлөлт 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдөр орсон байна. Энэхүү журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэснээс эхэлж, баривчлах, ял төлөвлөж, шүүх хурал үргэлжлэх ажиллагааг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, тухайн улсын шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь ял тохиролцох, гэм буруугийн асуудлаар шийдвэр гаргах, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх, шүүхийн өмнөх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны дагуу явагдах баталгаа болдог зэрэг өргөн агуулга, ач холбогдол бүхий процессын үе шат юм.

Хэдийгээр АНУ нь холбооны эрүүгийн процессын жишиг хуультай боловч муж бүр шүүх үйл ажиллагааг зохицуулдаг хууль, журамтай. Өөрөөр хэлбэл, муж улсуудын эрүүгийн процесс, түүнийг

<sup>23</sup> АНУ-ын Эрх Зүйн Тогтолцооны Товчоон, <https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf>. (Сүүлд үзсэн: 2025.03.01)

зохицуулдаг журмууд харилцан адилгүй боловч нийтлэг нэг үзэл баримтлал, Үндсэн хуулиар тогтоосон зарчимд захирагддаг байна.

АНУ-д Эрүүгийн хэргийн шүүх хурлын өмнө мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан байхыг холбооны Үндсэн хууль болон муж улсуудын тусгайлсан хууль шүүхийн шийдвэрийн дагуу байхыг шаарддаг. Энэхүү ажиллагааг нийтэд нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэх бөгөөд өөр өөр зорилготой хэд хэдэн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж болдог байна. Ерөнхийдөө шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь хэрэгт холбогдсон тухайн хүнийг гэмт хэрэгт буруутгах хангалттай үндэслэл байгаа эсэх, байгаа бол яллагдагчаар татах, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг батлан даалтад гаргах эсэх, нотлох баримтыг хуулийн дагуу цуглуулсан эсэх, нотлох баримтыг үнэлэх, хэргээ хүлээсэн тохиолдолд ял наймаалцах, иргэдийн төлөөлөгчдийг сонгох, талуудыг мэдээллээр хангаж, шүүх хурал болохоос өмнө хэргийн талаар тодорхой шийдвэр гаргах, ял төлөвлөх эсвэл хэргийг хаах, мэтгэлцэх нөхцөлийг тодорхой болгох гэх мэт зорилгоор явагддаг бөгөөд хамгийн гол нь шүүгчдэд хэргийн талаарх бодит мэдээллийг өгөх, хүний эрхийг хангах талаар оновчтой шийдвэр гаргахад туслах зорилгоор явагддаг. Урьдчилсан хэлэлцүүлэг их суудлын тангарагтны шүүхийн тогтолцоо хэрэглэхээ больсон ихэнх муж улсад яллагдагчийн хэргийг шүүх хурлаар хэлэлцэх магадлалтай үндэслэл байгаа эсэхийг тодорхойлохын тулд урьдчилсан хэлэлцүүлэг явуулдаг. Энэ хэлэлцүүлэгт яллах тал хэргийг танилцуулж, шүүгдэгч гэрчтэй нүүрэлдэх болон өөртөө туслах нотолгоог гаргах эрхтэй байдаг. Урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр хийгддэг гол ажиллагааны нэг бол нотлох баримтыг үнэлэх явдал юм. Шүүх эрүүгийн хэргийг шалган прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж олж авсан нотлох баримтыг хүчингүйд тооцож, хасдаг. Өмгөөлөгчөөс хуулийн шаардлагыг зөрчин олж авсан нотлох баримтыг хасуулах хүсэлт гаргавал түүнийг няцаах үүрэг нь прокурорт байдаг. Бусад тохиолдолд нотлох баримтыг үндэслэлтэйд тооцох үүрэг нь хүсэлт гаргаж байгаа талд хамаарна.

Мэтгэлцэх журам урьдчилсан хэлэлцүүлгийн дараагийн чухал зорилго бол мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх боломжоор хангах явдал юм. Оролцогч талуудаас гаргасан үндэслэл, шалтгаан, түүнтэй холбоотой баримт сэлтийг харилцан танилцах боломжоор хангах нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх, оролцогчдын гаргасан гомдол, хүсэлт түүнтэй холбоотой үйл баримт, хууль зүйн факттай танилцах, хариу няцаалт бэлтгэх боломжийг бий болгодог. Ингэснээр гэм буруугийн шүүх хурлын үед алдаа гарах магадлалыг

багасгаж хэргийг мөрдөн байцаалтад буцааж, хэрэг шийдвэрлэх ажиллагааг сунжруулахаас урьдчилан сэргийлдэг давуу талтай. Иймд шүүхийн шатнаас прокурорт буцаадаг зохицуулалт байдаггүй. Мэтгэлцэх журмын хэрэгжилт дээд цэгтээ энэ улсад хөгжсөн тул тухайн шүүхийн хэлэлцүүлгийг шийдвэрлэсэн шүүгч гэм буруугийн асуудлыг хэлэлцдэггүй байна.

АНУ-ын 28 дугаар кодекс буюу Шүүхийн тухай хуулийн 2106 дугаар зүйлд: “Дээд шүүх болон бусад давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий шүүхүүд хуулийн дагуу хянуулахаар ирүүлсэн шүүхийн шийдвэр, захирамж, тушаалуудыг баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болгох, эсхүл тэдгээрийн зарим хэсгийг болон үндэслэлийг буцааж, тухайн нөхцөл байдалд нийцсэн шийдвэр гаргуулахаар буцааж болно” гэж заасан.<sup>24</sup>Талуудын зүгээс анхан шатны шүүх процесс зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж үзэж буй тохиолдолд цааш давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Шүүгдэгчийг цагаатгасан хэрэгт прокурор давж заалдах гомдол гаргах эрхгүй байдаг. Энэ нь эрүүгийн эрх зүйн нэг гэмт хэрэгт нэг л удаа ял оногдуулах “double jeopardy” зарчмын үүднээс прокурор нэг удаа яллахад ашигласан нотлох баримтуудаараа дахин шүүгдэгчийг яллах ёсгүй гэж үздэгтэй холбоотой байна<sup>25</sup>. АНУ-д давж заалдах журмаар хэргийг хянан хэлэлцэж буй шүүхүүд шинэ нотлох баримт хүлээн авах байдлаар хэргийг дахин хянан шийдвэрлэх эрх хэмжээгүй буюу зөвхөн анхан шатны шүүх шударга процессоор дамжуулсан хэргийг хянан шийдвэрлэсэн, хуулийг зөв хэрэглэсэн эсэхэд л хяналт тавина<sup>26</sup>. Давж заалдах шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд дараах тохиолдлуудад доод шатны шүүхэд буцаана. Үүнд:

- Нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах,
- Өмнөх шийдвэрт гарсан зөрчилдөөний улмаас хэргийг дахин хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шүүх шийдсэн гэх мэт<sup>27</sup>.

АНУ-д “цагаатгах” буюу presumption of innocence / dismissal due to insufficient evidence-ийн зохицуулалт нь ОХУ шиг нэг хуульд төвлөрсөн биш, харин Үндсэн хууль, федерал болон мужийн эрүүгийн процессын дүрмүүд дээр суурилдаг. Үндсэн хууль (Constitution) 5th Amendmen Хүнд ял онохоос өмнө due process-ийг хангах, гэм бурууг нотлох талаар зохицуулалттай бөгөөд мөн хуулийн 14th

<sup>24</sup> Aaron-Andrew P.Bruhl, “The Remand Power and the Supreme Court’s Role, US”, (Nov, 2020), 185-186, <https://scholarship.law.wm.edu/cgi/viewcontent.cgi?article=3065&context=facpubs>, (last visited: March 9, 2023).

<sup>25</sup> Justia, Criminal Law Center, Criminal Appeals, <https://www.justia.com/criminal/procedure/criminal-appeals/>, (last visited: March 9, 2023).

<sup>26</sup> United States Courts, <https://www.uscourts.gov/aboutfederal-courts/court-role-and-structure/about-us-courts-appeals>, (last visited: March 9, 2023).

<sup>27</sup> Мөн тэнд.

Amendment Equal protection & due process “..бүх яллагдагчийн эрх тэгш, нотолгоо хангалтгүй бол ял оноохгүй байх” гэж зохицуулсан нь АНУ-д presumption of innocence буюу цагаатгах үндсэн зарчим болж үйлчилдэг. Pretrial motions (Rule 12) Шүүх прокурорын нотолгоо хангалттай эсэхийг шалгана. Прокурор нотолгоо хангалтгүй гэж үзвэл хэргийн хэрэгсэхгүй болгож болно. Энэ үйлдлийг nolle prosequi гэдэг бөгөөд шүүх зөвшөөрвөл хэрэг цуцлагдана. Нэмэлт мөрдөн байцаалт (Further Investigation) зарим тохиолдолд прокурор нотолгоог нэмэгдүүлэх боломжтой гэж үзэн үргэлжлүүлж болох боловч энэ тохиолдолд шүүх зөвхөн процедурын шаардлага хангагдсан эсэхийг хянаж, зөвшөөрөх эсэхийг шийддэг. Гэхдээ шүүхээс прокурорт буцааж шийдвэрлэдэггүй.

Federal Rules of Criminal Procedure-д урьдчилсан хэлэлцүүлэг (preliminary hearing) тусгайлан заасан бөгөөд зөвхөн тодорхой хэрэгт шаардлагатай үед зохион байгуулдаг буюу заавал хийх гэж бүх хэрэгт хуульчилсан заалт байхгүй, муж бүр өөрийн дүрэмтэй байдаг байна.

В. Холбооны Бүгд Найрамдах Герман улс<sup>28</sup>

Холбооны Бүгд Найрамдах Герман /цаашид ХБНГУ/ улсын эрүүгийн процесс шүүн таслах ажиллагаа нь мөрдөн шалгах зарчмын үндсэн дээр 3 үе шаттайгаар явагддаг.

- Нэгдүгээр үе шатанд: Прокурор мөрдөн шалгах ажиллагааг явуулж, яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулдаг байна.

- Хоёрдугаар үе шатанд: Шүүх хуралдааныг явуулах эсэхийг шийдвэрлэх, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шаттай байна. Сэжигтэн, яллагдагчийг шүүхээр хянан хэлэлцэхэд хангалттай эсэхийг хянасны үндсэн дээр шүүх хуралдаан явуулах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ үед яллагдагчийг дуудан ирүүлж, хэрэгт авагдаагүй нэмэлт нотлох баримт цуглуулах боломжийг олгож, өмгөөлөгчтэй уулзаж, хүсэлтийг сонсох, цагаатгах нотлох баримт бүрдүүлэх, гэрчүүдийн мэдүүлгийг шалгах зэрэг ажиллагаануудыг хийдэг байна. Хуулийн 202 дугаар зүйлд “... хэргийн бодит байдлыг сайтар судалж тогтоох зорилгоор шүүх нэмэлт нотлох баримт цуглуулахаар тогтоож болох ба түүнд хэн ч гомдол гаргах эрхгүй” гэж зохицуулж, үүний дараагаар шүүх гэм буруугийн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлаа шийдвэрлэдэг байна. Гэм буруугийн шүүх хуралдаанд прокурор зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол хуралдааныг завсарлаж, тэр дор нь шийдвэрлэхээр зохицуулсан байна. Гэвч шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх эсэхийг шалгаж үзсэн шүүгч тухайн хэрэгт шүүгчээр

<sup>28</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн, ЭБШ хууль дахь, шүүхээс нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах талаарх судалгааны ажлын тайлан, УБ 2012 он

оролцохыг хориглосон байдаг. /23.3 дугаар зүйл/

• Гуравдугаар үе шат: Шүүн таслах үе шат юм. Гэм буруугийн талаар хэлэлцэж, дахин хэргийг прокурорт буцаах зохицуулалт байхгүй ба хэргийг шийдвэрлэхэд эргэлзээ гарвал, хангалттай нотлогдохгүй тохиолдолд шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэдэг байна.

ХБНГУ-д давж заалдах ажиллагаа нь доод шатны шүүхийн алдааг засах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой. Эрүүгийн процесст давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үйл баримтын эсрэг “Berufung”, хууль хэрэглээний эсрэг “Revision”, шүүхийн бусад шийдвэрийн эсрэг “Beschwerde” гомдол гаргах ажиллагаа гэж гурван төрөлд хуваадаг<sup>29</sup>. Шүүх гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, тогтоогдсон хэргийн үйл баримтад тулгуурлан шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл, “Berufung” зарчмаар давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүх шүүгдэгчийн гэм буруу болсон хэргийн үйл баримтын талаар өөрийн дүгнэлтийг өгөх эрхтэй. Оногдуулсан ял шийтгэлийн эсэргүүцэж, гомдол гаргасан бол ялыг өөрчлөх эрхтэй ч “reformation in reus” буюу өмнөх шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлж оногдуулахгүй байх зарчмыг баримтална. Давж заалдах шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрийг ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуулийн 352 дугаар зүйлд зааснаар зөвхөн гомдолд дурдагдсан асуудал болсон үйл баримтын хүрээнд хянан хэлэлцэнэ. ХБНГУ-ын Эрүүгийн эрх зүйн судлаач Майкл Бонлайндерын тайлбарлаж буйгаар гомдол гаргагчаас дэвшүүлсэн үйл баримт нь гомдолд тусгагдсан тухайн нэг процессын зөрчилтэй хамааралгүй бөгөөд гомдолд дурдахааргүй бусад зөрчлийг илэрхийлж байвал шүүхээс сүүлд илэрсэн зөрчлийн хүрээнд шийдвэр гаргаж болно<sup>30</sup>.

Хэргийг прокурорт буцаах тухай зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн “Revision” төрлөөр давж заалдах ажиллагаа явуулах үед тухайн хэрэг үйл баримтын болон хууль хэрэглээний алдаа аль аль нь илэрсэн тохиолдолд хэргийг доод шатны шүүх рүү буцааж болно. ХБНГУ-д шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зохицуулалт Япон, Хятад хоёртой харьцуулахад илүү нарийн, хуульчлагдсан байдаг. Эрүүгийн процессын хууль (Strafprozessordnung, StPO)-д шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг Vorverfahren буюу шүүхийн урьдчилсан шат гэж тодорхойлсон. Үүнд прокурор, шүүх, сэжигтэн болон өмгөөлөгч оролцдог. Энэхүү шатанд хэрэгт нотолгоо хангалттай эсэхийг шалгах,

<sup>29</sup> Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012, p.251 үзсэн огноо: 2023.03.09, <https://b-ok.asia/book/3656000/4e3da3>,

<sup>30</sup> Micheal Bohnlander, *өмнөх эшлэл* 28, 255.

сэжигтэнд ял тулгах эсэхийг урьдчилан шийдвэрлэх, хэргийн ач холбогдлыг тодорхойлох зорилготой. Урьдчилсан шатанд (Pre-trial / Vorverfahren) прокурор хэрэгт нотолгоо хангалттай эсэхийг шалгадаг. Хэрвээ нотолгоо дутуу байвал нэмэлт нотолгоо цуглуулах эсвэл хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэрийг прокурор гаргана. Шүүхийн шатанд (Trial stage) шүүх нотолгоо хангалтгүй гэж үзвэл цагаатгах эсвэл хэргийг прокурорт буцаах (remand to prosecutor) боломжтой. Прокурор энэ үед нэмэлт нотолгоо цуглуулж, дахин яллах эсэхийг шийддэг. Германд adversarial elements илүү хөгжсөн (§136, §160–162 StPO) өмгөөлөгч болон прокурор шүүхэд нотолгоо, тайлбар тавих эрхтэй. Шүүх зөвхөн дүн шинжилгээ хийхгүй, мөн талуудын мэтгэлцээн дээр үндэслэн шийдвэр гаргана гэж зохицуулснаар мэтгэлцэх зарчим агуулагдсан байна. Эдгээр мэдээллээс үзэхэд тус улсад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болоод гэм буруугийн шатанд прокурорт хэргийг буцааж шийдвэрлэдэг. Тухайн шийдвэр тус улсад үйлчилдэг цагаатгах болон мэтгэлцэх зарчимтай мөн Монгол улс шиг харшилдаг гэх үр дүн харагдаж байна.

Энэ тухайд ХБНГУ-ын эрдэмтэд болох Prof. Dr. Klaus Tiedemann: Германы эрүүгийн эрх зүйн салбарт нэр хүндтэй эрдэмтэн, шүүмжлэлтэй ханддаг. Мөн Prof. Dr. Hans-Jürgen Papier: Германы Үндсэн хуулийн шүүхийн дарга асан, эрх зүйн үндсэн зарчмуудыг хамгаалаг,

Prof. Dr. Michael Kubiciel: Эрүүгийн эрх зүйн профессор, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон прокурорт буцаах асуудлаар судалгаа хийдэг шүүмжлэлттэй ханддаг бөгөөд тус хуулийн §170 StPO зүйлд заасан прокурорт буцаах зохицуулалтад шүүмжлэлтэй ханддаг байна. Ингэхдээ шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зайлшгүй хийх нэг үе шат болгох талаар хуульчлаагүй байна.

Г. Япон улс<sup>31</sup>

Япон улс нь 1946 онд шинэ Үндсэн хуулиа баталсны дараа Эрүүгийн процессын хууль тогтоомжоо түүнд нийцүүлж гаргах замаар гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тогтолцоог өөрчлөн шинэчлэх болсон билээ. 1948 онд Японы Эрүүгийн процессын хууль шинээр батлагдан гарчээ. Энэ хууль нь Японы Үндсэн хуулийн суурь зарчмуудыг тусгаж, нотлох ажиллагааны шалгуурыг шинэчлэн шүүхийн мэтгэлцүүлэн хэлэлцэх журмыг тогтоосноос гадна процессын оролцогчдын эрхийг зааглан хуульчилж өгснөөрөө түүхэн ач холбогдолтой.

<sup>31</sup> 昭和二十三年法律第三百一十一号刑事訴訟法, 1948 оны 131 дүгээр хууль эрүүгийн байцаан шийтгэх хууль, [https://elaws.e-gov.go.jp/document?lawid=323AC0000000131\\_20240215\\_505AC0000000066&fbclid=IwAR3SZ5MVzBooAITCyXYbcRffOXE2yC8cpITGdlj6dijWSdUTpLsz\\_0ekGGY](https://elaws.e-gov.go.jp/document?lawid=323AC0000000131_20240215_505AC0000000066&fbclid=IwAR3SZ5MVzBooAITCyXYbcRffOXE2yC8cpITGdlj6dijWSdUTpLsz_0ekGGY), (Сүүлд үзсэн: 2024.04.25).

Японы Эрүүгийн шүүхийн шүүх хуралдаан нь Америкийн шүүхийн чөлөөт мэтгэлцээний зарчмыг ихэнх агуулгаар тусгаж, шүүн таслах ажиллагааны бүхий л явцад уг зарчим сонгодог утгаар хэрэгждэг гэж үзэж болно. Онц ноцтой зарим эрүүгийн хэргийг шүүхээр хэлэлцэхэд тангарагтны төлөөлөгч гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоотой. Эрүүгийн процессын хуулийн 41-р зүйлд: “... Өмгөөлөгч нь хуулийн тусгайлан олгогдсон эрхийн дагуу бие даан өмгөөллийн үйл ажиллагаа явуулна” гэж заажээ. Өмгөөлөгчид хуулиар олгогдсон эрхэд нотлох баримтыг цуглуулах, өөрийн биеэр хэргийн газрын үзлэгт оролцох, үзлэгийг газар дээрээс нь зураг авах, яллагдагчийг байцаахад зарим үед байлцах, гэрч нараас асуулт асуух, шинжээчтэй уулзаж ярилцах зэрэг эрхээр хангагдсан байдаг. Эрүүгийн процессын хуулийн 298.1-р зүйлд: “Прокурор, шүүгдэгч, өмгөөлөгч нь нотлох баримтыг шүүхээр шинжлэн судлуулахаар хүсэлт гаргах эрхтэй” гэж заасан бол мөн хуулийн 312.1-р зүйлд: “Шүүх нь прокурор яллах дүгнэлт үйлдэж, хүсэлт гаргасан тохиолдолд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай актад заасан шүүхэд шилжүүлэх үндэслэл, шалтгаан, яллах дүгнэлтийн агуулга болон нэмэлт хийх, өөрчөх, татгалзах, талаар шүүхээр хэлэлцүүлэх эсэх талаар шийдвэр гаргана” гэж дурджээ<sup>32</sup>. Мөн хуулийн 298.2-р зүйлд: “Шүүгч нь хэрэгтэй, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрийн санаачлагаар нотлох баримтыг шалгах, шинжлэн судлах эрхтэй” гэж заасан. Энэхүү зохицуулалт нь мэтгэлцэгч талуудын аль нэг нь тэгш бус байр суурьтай байгаа тохиолдолд оролцогчдын эрх, үүргийг хамгаалахын тулд шүүгч өөрийн санаачлагаар нотлох баримтыг дахин шалгах, шинжлэн судлах, баримт сэлтүүдийн нотлох чадварыг эргэн хянаж эргэлзээгүй байдал хангагдсан эсэхийг эцэслэн тогтооход чиглэгдэнэ. Зарим судлаачид энэ зохицуулалтыг мөрдөн шүүх тогтолцооны хэв шинж тусгагдсан гэж үзэх нь бий<sup>33</sup>.

Япон улсад прокурорт даалгаж шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалт байхгүй. Учир нь шүүгч болон прокурор нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр өөр үүрэгтэй, бие даан ажилладаг гэдгээрээ онцлог. Шүүхийн үндсэн үүрэг бол шүүх хуралдааныг шударгаар явуулах явдал юм. Шүүх нотлох баримтыг хянаж үзээд хуулийн дагуу шийдвэр гаргадаг. Шүүхийн төвийг сахих, шударга байдлыг хангах үүднээс прокурор болон бусад талуудаас хараат бус байр суурьтай байдаг бол прокурорууд эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, яллах ажиллагааг хариуцаж, шүүхэд нотлох баримт гаргаж, шүүх хуралд оролцоно. Шүүгч шүүх хуралдаанд прокуророос

<sup>32</sup> Должингийн Баярсайхан, Япон улсын 2015 оны Эрүүгийн Процессын хуулийн 312 дугаар зүйл.

<sup>33</sup> Должингийн Баярсайхан, *Өмнөх эшлэл 5*, 147 дахь тал.

гаргасан нотлох баримт, нотлох баримтыг судалж, өөрийн дүгнэлтийг гаргадаг.

Мэтгэлцэх зарчмын (Adversarial vs Inquisitorial) тухайд Япон улс нь инквизицион систем (inquisitorial system)-ийг баримталдаг бөгөөд прокурор болон мөрдөн байцаагч гол үүрэгтэй, шүүхийн үүрэг нь нотолгоо хянах, маргааныг шийдэхэд хязгаарлагдмал. Яллагдагчийн өмгөөлөгчийн мөн манай улс шиг хязгаарлагдмал эрхтэйгээр оролцдог.

Япон Улсад presumption of innocence буюу цагаатгах зарчим Үндсэн хууль (Article 31) болон Pretrial conference (公判前整理手続 / pretrial conference procedure) нь шүүх, прокурор, өмгөөлөгч нарын хооронд анхных буюу шүүх хурал эхлэхийн өмнө зохион байгуулдаг процесс. Энэ нь:

- Сул зүйлийг тодорхойлох, маргааны гол асуудлуудыг ялгах;
- Шүүхэд танилцуулах нотлох баримтыг жагсаах (evidence-list / disclosure);
- Шүүх хуралд оруулах эсэх, ямар гэрч, баримтыг дуудахаа тохиролцох;
- Шүүх хурал үр дүнтэй, төвлөрсөн, шуурхай явагдах төлөвлөгөө гаргах зориулалттай.

Saiban-in (裁判員) хэрэг-т pretrial conference болох нь заавал шаардагддаг; бусад хүнд ноцтой хэрэгт шүүхийн шийдвэрээр (discretion) заавал эсвэл хэрэг бүрэн шинжлэх байдлаар зохион байгуулах эрхтэй<sup>34</sup>. Япон улсад “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг” (pretrial conference / 公判前整理手続) гэдэг нь зарим хэрэгт заавал хийгдэхээр хуульчилсан байдаг. Жишээ нь иргэдийн оролцоотой хэрэг (Saiban-in trial) бол заавал урьдчилсан хэлэлцүүлэг хийнэ. Харин бусад хэргийн хувьд, шүүх өөрөө үзвэл хийдэг буюу бүх хэрэгт бус зөвхөн тодорхой төрлийн гэмт хэрэг эсхүл ноцтой хүнд гэмт хэргүүдэд хийгддэг байна.

Д. Бүгд Найрамдах Хятад Ард улс<sup>35</sup>

Хятад нь социалист дэглэмтэй ардчилсан бус орон боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд инквизицийн мөрдөн шалгах уламжлалыг аккаусацийн мэтгэлцүүлэн шүүх зарчимтай маш өвөрмөц аргаар хослуулж, эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны хаалттай нөхцлийг улс, орны онцлогт нийцсэн байдлаар зохицуулж иржээ.

БНХАУ-ын Үндсэн хууль<sup>36</sup>, Ардын шүүх байгуулах хуулийн 12

<sup>34</sup> Supreme Court of Japan+1, Сүүлд үзсэн огноо: 2025.09.01.

<sup>35</sup> Должингийн Баярсайхан, *Өмнөх эшлэл 5*, 117 дахь тал.

<sup>36</sup> БНХАУ-ын Үндсэн хуулийн 129 дүгээр зүйл /中华人民共和国宪法/, <https://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116>, (Сүүлд үзсэн: 2023.03.22).

дугаар зүйлд зааснаар улсын шүүх тогтолцоо нь Ардын дээд шүүх, Газрын шат шатны ардын шүүх, Цэргийн шүүх зэрэг тусгай шүүхээс бүрдэх бөгөөд Ардын дээд шүүх нь газар бүрийн шат шатны ардын шүүх, тусгай ардын шүүхийн шүүн таслах ажлыг хянана. Өөрөө хэлбэл дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн шүүн таслах ажлыг хянах буюу газрын шат шатны ардын шүүх нь дээд шатны шүүх, дунд шатны шүүх, үндсэн шатны шүүхэд тус тус хуваагдана. Харин Тусгай ардын шүүхийн бүтцэд цэргийн, далайн, санхүү, оюуны өмчийн шүүхүүд багтана гэж хуульчилжээ<sup>37</sup>.

Эрүүгийн процессын хуулийн 150 дугаар зүйлд зааснаар “... Шүүх нь прокурорын зөвшөөрч шилжүүлсэн яллах нэхэмжлэл бүхий эрүүгийн хэргийг хянаж, шалгасны дараа зайлшгүй шүүхээр ял оногдуулах бодит шаардлага нь хангагдсан бол гэрч болон гэрчлэх баримтын жагсаалт, гол гэрч, гэрчлэх мэдүүлсэн баримтын гэрэл зураг дагалдуулсан материал зэрэг үндсэн нотолгооны баримтууд бүрэн цугларсан нөхцөлд шүүх хуралдаанаар хэлэлцэх ажиллагааг эхлүүлнэ. Мөн хуулийн 158 дугаар зүйлд зааснаар шүүх танхимд эрүүгийн хэргийг шүүн хэлэлцэх явцад нотлох баримтад эргэлзээ төрвөл шүүх хурлыг завсарлаж, нотлох баримтыг шалган үнэн зөв байдлыг дахин нягталж болно.

Анхан шатны ардын шүүх прокуророос шилжүүлсэн эрүүгийн хэргийг хянаж тус шүүхийн харьяалалд хамаарахгүй, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх шаардлагатай зэрэг тохиолдолд буцаах эрхийг Ардын дээд шүүхийн тайлбараар нарийвчлан зохицуулсан байна. Тодруулбал шүүхээс бие даан хэргийг прокурорт буцаах эрхгүй боловч, прокурорын саналыг шүүх хүлээн авч, шүүх хуралдааныг 1 сар хүртэлх хугацаагаар хойшлуулах эрхтэй байна<sup>38</sup>. Харин давж заалдах шатны шүүх буюу хоёрдугаар шатны шүүхийн эрх хэмжээг гомдол, эсэргүүцлийн хүрээнд хязгаарлагдахгүй анхан шатны шийдвэрээр тогтоосон бодит байдал, хуулийн хэрэглээг бүхэлд нь хянах. Мөн бүлэглэж гүйцэтгэсэн гэмт хэргийг зөвхөн хэсэг шүүгдэгч давж заалдсан бол хэргийг бүхэлд нь хянаж нэгтгэж шийдвэрлэнэ.<sup>39</sup>

Анхан шатны ардын шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан процессыг зөрчсөн дараах нөхцөл байдлын аль нэгийг давж заалдах шатны ардын шүүх илрүүлсэн бол шийдвэрийг хүчингүй

<sup>37</sup> БНХАУ-ын Ардын шүүх байгуулах хууль, /中华人民共和国人民法院组织法/ [https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content\\_5334895.htm](https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm), (Сүүлд үзсэн: 2023.03.22).

<sup>38</sup> Эрүүгийн процессын хуулийг хэрэглэх талаар Ардын дээд шүүхийн тайлбар, 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释[http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204\\_3124003.shtml](http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204_3124003.shtml), (Сүүлд үзсэн: 2023.03.22).

<sup>39</sup> БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 233 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/, <http://www.npc.gov.cn/npc/index.html>, (Сүүлд үзсэн: 2023.03.22).

болгож дахин хэлэлцүүлэхээр тухайн шатны ардын шүүхэд буцаана<sup>40</sup>. Давж заалдах шатны ардын шүүхэд шүүгдэгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, ойр дотнын хүнээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ шүүгдэгчийн ялыг хүндрүүлэхгүй. Давж заалдах шатны ардын шүүх тухайн шатны ардын шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэгт ардын прокурорын газраас нэмж шинэ гэмт хэрэг үйлдсэн бодит байдлыг заалдсанаас бусад тохиолдолд тухайн шатны ардын шүүх шүүгдэгчийн ялыг хүндрүүлэхгүй байхаар хуульчилсан байна<sup>41</sup>.

Criminal Procedure Law, Article 12 “No one shall be found guilty without sufficient evidence.”

Прокурор нотолгоо хангалтгүй гэж үзвэл хэрэгт цагаатгах шийдвэр гаргах тухай дурдсан боловч цагаатгах зарчим албан ёсоор тусгагдаагүй, гэхдээ нотолгоо хангалтгүй бол прокурор хэрэг үүсгэхээс татгалзаж, практик байдлаар сэжигтнийг буруутай гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, цагаатгах нь прокурорын шийдвэртэй шууд холбоотой, шүүх шууд буцааж нэмэлт нотолгоо цуглуулах эрх хязгаарлагдмал. Хятад улсад Японы болон барууны “шүүхэд мэтгэлцэх (adversarial) зарчим” шууд хэрэгждэггүй, харин микс буюу хос (inquisitorial + adversarial) систем нь голчлон хэрэгждэг. Эрүүгийн процессын хуульд Япон шиг “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг (pre-trial hearing)” гэсэн тусгай шат заагдаагүй. Харин хуулиар тодорхой зааснаар шүүх хяналтын болон урьдчилсан шатны хяналт /审查程序 (review procedure) нь хэрэгт нотолгоо хангалттай эсэхийг шалгах зарчмаар зохицуулагддаг. 审查起诉 (Shěenchá qǐsù) – прокурорын хэрэг шалгах / урьдчилсан хяналт прокурор нотолгоо хангалтгүй бол хэрэг үүсгэхээс татгалзаж болно (Criminal Procedure Law, Article 169).

Шүүх прокурорын шийдвэрийг хянах эрхтэй, гэхдээ Японы “pre-trial hearing”-ийн шиг бие даасан шүүхийн хэлэлцүүлэг хязгаарлагдмал. 审判前程序 (Pre-trial procedure) шүүх хэргийн материалыг шалгаж, нотолгоо хангалттай эсэхийг нягтлах. Шүүх хуралдаан мэтгэлцээний үндсэн дээр явагдах бөгөөд шүүхээс нотлогдохгүй бол цагаатгах эрхтэй ч прокурорт хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаадаг. Гэхдээ нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах зохицуулалт байхгүй боловч, шүүхийн практикаар ийнхүү буцааж шийдвэрлэдэг байна.

<sup>40</sup> БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 238 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/ , URL:<http://www.npc.gov.cn/npc/index.html>, (Сүүлд үзсэн: 2023.03.22).

<sup>41</sup> БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 236 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/ URL:<http://www.npc.gov.cn/npc/index.html>, (Сүүлд үзсэн: 2023.03.22).

## V. Дүгнэлт

Дээрх сонгосон улсууд нь эх газрын болоод англи саксоны эрх зүйн бүлд хамаарах өндөр хөгжилтэйд тооцогддог улс бөгөөд эдгээр улсуудад бүгдэд нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэх зохицуулалт агуулагдсан байна. Манай улстай ижил түвшинд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг тодорхой нэг үе шат болгон авч үзсэн улсуудад ЗХОУ, АНУ, Япон, ХБНГУ багтах бөгөөд БНХАУ-ын тухайд шүүхийн бэлтгэл хангах ажиллагаа буюу арай явцуу хүрээнд мөрдөн шалгах зарчим шүүхийн шатанд хэрэгждэг байна. Бидний үлгэр дууриалал авдаг ЗХОУ, ХБНГУ зэрэг улсуудад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэгдэх асуудлыг хаалттай хүрээнд тоочиж, манай улстай ижил байдлаар зохицуулсан байна. Гэвч ялгаагүй л шүүх хуралдааны явцад тус хэлэлцүүлгийг заавал хийхээр хуульчилж өгөөгүй бөгөөд манай улсаас ялгаатай байгаа хүнд төрлийн онц ноцтой гэдэг шалгуураар зайлшгүй хийх тухай зохицуулалт байгаа болно. Мөн тус хэлэлцүүлгийг шүүх өөрийн санаачилгаар зарлаж, прокурорт чиглэл өгөх нь яллах хэв шинжийг агуулсан гэдгийг илтгэж байна. ХБНГУ, ОХУ, МУ-нь холимог тогтолцоотой бөгөөд аль ч улсын хувьд шүүхийн шатанд мэтгэлцэх зарчим үүргээ бүрэн гүйцэтгэхгүй байна. Япон улсын тухайд эрх мэдлийн хуваарилалтыг тэнцвэртэй байдлаар хувааж чадсан бөгөөд тус хэрэгт хийгдэх ажиллагаанд прокурор, өмгөөлөгч нарын байр суурийг харгалзаж хэргийг шийдвэрлэдэг байна. Мөн өмнө дурдсан улсуудтай ижил байдлаар шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг тодорхой хуульд заасан үндэслэлээр л хурлыг товолдог байна. Америк улсад мэтгэлцэх зарчим хөгжиж мөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үүсэл хөгжил энэ улсад явагдсан тул бүх хэрэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг заавал хийж тус үе шатыг дамжран өнгөрдөг байна. Тухайн хэлэлцүүлгийг шүүсэн шүүгч гэм буруугийн хэлэлцүүлэгт оролцуулахыг хориглодог бөгөөд гэм бурууг өөр шүүгч нарын бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг онцлогтой байна. Энэ улсад гэм бурууг хэлэлцэх шатанд шүүх хуралдааныг хойшлуулах, прокурорт даалгах гэх зохицуулалт байхгүй бөгөөд due process бүрэн хэрэгжиж нотлогдоогүй бол цагаатгаж, прокурорт хариуцлага тооцдог систем хэрэгждэг байна.

Монгол болон Орос, Герман улсын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, түүнийг явуулах үндэслэл, прокурорт даалгах зохицуулалт зэрэг нь ижил байдлаар зохицуулагджээ. Холимог системд хамаарах буюу мэтгэлцэх, мөрдөн шалгах зарчмыг уялдаа холбоотойгоор ашиглах нь эрүүгийн процесс ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд шүүхийн шатанд мэтгэлцэх зарчмын

хэрэгжилтийг хангаснаараа нэг талаараа тус шүүхийн хэлэлцүүлгийн зорилгыг хангаж, яллах шүүхийн хэв шинжийг устгаж, хүний эрхийг хангасан зохицуулалт болоход тус дэм болно гэж судлаачийн зүгээс үзлээ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь АНУ-ын адил заавал дамжин өнгөрөх нэг үе шат болж үүнд хэргийн оролцогчид идэвх чармайлттай оролцон, шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлэгт урьдчилсан хэлэлцүүлэгт тусгагдсан давхар зохицуулалтыг халж, яллах шүүхийн хууч хамаарлыг үгүй болгосноороо шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго биелэлээ гэж үзэх юм.

[Ном зүй]

АНУ-ын Эрх Зүйн Тогтолцооны Товчоон, <https://photos.state.gov/libraries/mongolia/82677/PDF/US-Legal-system.pdf>.

БНХАУ-ын Ардын шүүх байгуулах хууль, /中华人民共和国人民法院组织法/, [https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content\\_5334895.htm](https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm).

БНХАУ-ын Эрүүгийн процессын хууль, /习近平会见 美国工商界和战略学术界代表/, <http://www.npc.gov.cn/npc/index.html>.

БНХАУ-ын Үндсэн хууль, /中华人民共和国宪法/, <https://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116>.

Должингийн Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2015 он.

Должингийн Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, (2 дахь хэвлэл), Улаанбаатар: Соёмбо, 2012 он.

Жамбаачүлтэмийн Эрхэсхулан, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хэрэглээний зарим асуудал”, Эрх зүй, 46 (2), 2019 он.

Нээлттэй нийгэм форум, “Нотолгооны өнөөгийн практик, арга зүй техник”, [https://cdn.greensoft.mn/uploads/users/88/files/Evidence\\_Web\(1\).pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/88/files/Evidence_Web(1).pdf), 2021 он,

Хууль зүйн үндэсний хүрээлэн, “ЭБШ хууль дахь, шүүхээс нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах талаарх судалгааны ажлын тайлан”, 2012 он.

Хүний эрхийн хороо, 32-р ерөнхий зөвлөмж.

Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлэг, Бодлого судалгааны тайлан”, [https://forum.mn/uploads/site/1126/res\\_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf](https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf), 2020 он.

Эрүүгийн процессын хуулийг хэрэглэх талаар Ардын дээд шүүхийн тайлбар, 最高人民法院关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释, [http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204\\_3124003.shtml](http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204_3124003.shtml).

Должингийн Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, онол практикийн хэлэлцүүлэг, /Илтгэлийн эмхэтгэл/, Улаанбаатар: 2017 он.

Япон улсын Үндсэн хуулийн веб, 昭和二十一年憲法日本国憲法, URL:<https://elaws.e-gov.go.jp/document?lawid=321CONSTITUTION>.

“Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ФЗ URL: [https://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_34481/](https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/).

昭和二十三年法律第三百三十一号刑事訴訟法, 1948 оны 131 дүгээр хууль эрүүгийн байцаан шийтгэх хууль, [https://elaws.e-gov.go.jp/t?lawid=323AC000000131\\_20240215\\_505AC0000000066&fbclid=IwAR3SZ5MVzBooAITcyXYbcRffOXE2yC8cpITGdIj6dijWSdUTpLsz\\_0EkGGY](https://elaws.e-gov.go.jp/t?lawid=323AC000000131_20240215_505AC0000000066&fbclid=IwAR3SZ5MVzBooAITcyXYbcRffOXE2yC8cpITGdIj6dijWSdUTpLsz_0EkGGY).

Aaron-Andrew P. Bruhl, “The Remand Power and the Supreme Court’s Role, US”, (Nov, 2020), <https://scholarship.law.wm.edu/cgi/viewcontent.cgi?article=3065&context=facpubs>.

Justia, Criminal Law Center, Criminal Appeals, <https://www.justia.com/criminal/procedure/criminal-appeals/>,

Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012, <https://b-ok.asia/book/3656000/4e3da3>.

United States Courts, Fedearal Probation, [https://www.uscourts.gov/sites/default/files/71\\_2\\_6\\_0.pdf?utm\\_source=com](https://www.uscourts.gov/sites/default/files/71_2_6_0.pdf?utm_source=com), <https://harvardlawreview.org/print/vol-137/bail-at-the-founding/>, [https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein\\_Origins\\_of\\_Public\\_Prosecution\\_at\\_Common\\_Law.pdf?utm\\_source=chatgpt.com](https://law.yale.edu/sites/default/files/documents/pdf/Faculty/Langbein_Origins_of_Public_Prosecution_at_Common_Law.pdf?utm_source=chatgpt.com).

United States Courts, <https://www.uscourts.gov/about-federal-courts/court-role-and-structure/about-us-courts-appeals>.

**[Abstract]**

**The Imperfections of The Preliminary  
Hearing and Its Consequences**

**Enkhzul Enkh-Yalalt**

*Bachelor of Laws (LL.B.).  
Ulaanbaatar, Mongolia*

In Mongolia, the regulation of the preliminary hearing was previously known under the term “pre-trial preparation,” but it had not been codified as a distinct stage of proceedings as it is today. In resolving a case, both the accused and the victim, as equal human beings entitled to dignity, enjoy equal rights and obligations to participate in investigative proceedings. Accordingly, the legislator provided for the protection of human rights and the resolution of procedural issues, such as preparation for the trial, through this mechanism. Although the introduction of the preliminary hearing achieved the legislator’s intended purpose of formalizing such a stage, its practical effectiveness has remained unsatisfactory, which serves as the basis for this research. The incomplete implementation of the preliminary hearing is due to several factors: the lack of active participation by the parties; the absence of a mandatory provision requiring such a hearing; and the possibility for the court, even at the trial stage, to postpone proceedings by issuing instructions to the prosecutor under the pretext of issues that should have been addressed during the preliminary hearing. These conditions have enabled the return of cases for additional investigation under the guise of prosecutor’s instructions, thereby allowing judges to determine guilt based on their initial internal conviction, reflecting accusatory tendencies within the judiciary. Ultimately, this undermines the adversarial principle at the trial stage and produces negative consequences in practice. On the basis of a comparative analysis between Mongolia and other jurisdictions that regulate preliminary hearings differently—including those with fully developed adversarial systems—the research proposes potential amendments to the legal framework governing preliminary hearings in Mongolia, aimed at ensuring the proper realization of adversarial principles during trial.

**[Keywords]**

Pretrial Hearing, Returning the Case to the Prosecutor, Assigning the Case to the Prosecutor for 60 Days, Concept of Law.